

Course: Basic Information Technology Skills

Lecture 13

InDesign, tools, working for a publishing

Prof. Tuyatsetseg Badarch, PhD, MBA.

2023

Adobe InDesign CS 5 програм

Хэвлэлийн эх бэлтгэдэг олон төрлийн програм байпаг. Эдгээрийн дотроос **Adobe** фирмийн **InDesign** програмыг дэлхий даяар өргөн хэрэглэх болж байна. Энэ програм нь **Adobe** фирмийн бусад програм болох **Photoshop, PageMaker, Illustrator, Acrobat** зэрэг програмтай хэрэглээ нь нэгтгэгдсэн бөгөөд **Photoshop** програмын **Layers, Colors** зэрэг үйл ажиллагаа, **PageMaker** програмын ном бүтээх технологиудыг бүрэн ашигладаг зэргээрээ шилдэг програм болж чадсан байна.

Програмын ажлын талбарыг нээх

Adobe inDesign програмыг нээхэд үндсэн гурван хэсгээс бүрдсэн **Quickstart** цонх гарч ирнэ. (Зураг 1). **Quickstart** цонхонд шинээр хуудас үүсгэхэд

File-New-Document (Шинээр хуудас үүсгэх)


File- New - Book (Шинээр ном үүсгэх)

File- New- Library (Шинээр номын сан үүсгэх) гэсэн командуудыг ашиглана. Харилцах цонхноос **Create a new document** гэсэн хэсгийг сонгоно.

Дараа нь шинэ хуудас нээхэд зураг 1-д үзүүлсэн харилцах цонхонд цаасны хэмжээг өөрчлөн тохируулах боломжтой.

Энэ гүйцэтгэлийг **Edit -Preferences - Unit & Increments** гэсэн хэсэгт зааж өгнө.

Зураг 1 **InDesign** програмын
үндсэн цонх



Дээрх харилцах цонхноос хуудасны тохиргоогоо хийж дууссан бол **Ok** гэсэн хэсгийг дарна. Энгээд таны тохируулсан цоо шинэ хуудас гарч ирнэ.

Програмын цонх.

Програмын цонх нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Эдгээрт:

- Програмын ажлын талбар болон цэсүүд
- Програмын багажууд болон палитрууд
- Програмын хуваарийн шугам болон тиг зураасууд багтана.

Програмын цонх буюу ажлын талбарт хэвлэлийн эх бэлтгэх хуудас цаас байрлах ба мөн цэс (**Menus**), багажууд (**Tools**), палитрууд, хэмжигч шугамууд, масштаб, хуудасны тоо бүхий навигаторууд байрлана.

Програмын цонх буюу цэснүүдэд


- **File:** Файлыг нээх, хаах, хэвлэх, зургийн импорт экспортыг хийх гэх мэт
- **Edit:** Объектыг хуулах, зөөх, үржүүлэх, засварлах боломжууд, өнгөний ерөнхий тохиргоо, текст хайх, үйлдэл буцаах гэх мэт

- **Layout:** Текстийг хэд хэдэн баганаар өрөх, мөр багана хоорондын зайг тохируулах, хуудасны дугаар, автомат тохиргоо гэх мэт
- **Type:** Үсгийн фонт, хэмжээ сонгох, зэрэгцүүлэх, муруй шугамын дагуу текст бичих гэх мэт тексттэй ажиллах гэх мэт
- **Object:** Объектуудын байрлалыг тодорхойлох, тэдгээрийг нэгтгэхээс гадна зураг текстийн харилцан байршлын тохиргоог хийх гэх мэт
- **Table:** Хүснэгттэй ажиллах гэх мэт
- **View:** Хэвлэлийн эхийн хуудсыг дэлгэцэнд харуулах боломжуудыг агуулна. Жишээ нь зөвхөн нэг хуудас юмуу эсвэл хоёр, дөрөв гэх мэт
- **Window:** Програм дээр ажиллах боломжуудыг агуулсан плитруудыг дэлгэх болон хураах, хэд хэдэн файлыг зэрэгцүүлэн нээж, хулганын **drag and drop** үйлдлээр хооронд нь файл солилцох гэх мэт
- **Help:** Тусламжийн файл гэх мэт командууд агуулагдана.

InDesign програм дээр ажиллахад шаардлагатай багажууд нь **Toolbox**-т байрлах ба энэхүү багажийн самбарыг **Window** цэсний **Tools** командаар харуулна.

InDesign програм нь текст, хүснэгт, хуудастай ажиллах гэх мэт олон төрлийн палитруудыг өөртөө агуулдаг. Жишээлбэл зураг 2-д:

- **Layers:** Давхаргуудтай ажиллах
- **Gradient:** Өнгөний уусгалт, дүүргэлт хийх
- **Pages:** Хуудастай ажиллах зэргийг үзүүлэв.




Зураг 2. Зарим палитрууд

Түүнчлэн зураг 3-д **Window** цэсний палитруудыг хэрхэн гаргаж ирэхийг үзүүлэв. Эдгээрт


- **Swatches:** Өнгө будагтай ажиллах
- **Text Wrap:** Тексттэй ажиллах
- **PathFinder:** Дүрс огтлолцуулах зэрэг олон палитрууд байна.

Ихэнх палитр нь **Windows** цэсэнд байрлах ба ганц **Library** палитр нь **File** цэсэнд, **Find/Change** палитр нь **Edit** цэсэнд байрладаг.



Зураг 3 **Windows** цэсний палитрууд

Зураг 4-д **InDesign** програмын үндсэн багажнуудыг үзүүлж, командуудыг тайлбарлан оруулав.



- ❖ **Direct selection tool** - Группээр сонгох зангилаа цэгээр дүрс засах, салгаж сонгох
- ❖ **Type tool** - Текст оруулах засварлах
- ❖ **Line tool** - Текст оруулах засварлах
- ❖ **Rectangle tool** – Вектор дүрс үүсгэх
- ❖ **Scale tool** – Объектыг масштаблах
- ❖ **Free Transform tool** – Чөлөөт масштаб
- ❖ **Gradient tool** – Уусгалттай дүүргэлт
- ❖ **Scissors tool** – Объектын хүрээг сэтлэх
- ❖ **Free Transform tool** – Чөлөөт масштаб
- ❖ **Formatting effects text** – Текстын эффект
- ❖ **Apply none** – Будаг шугамгүй болгох
- ❖ **Bleed mode** – Ажлын талбарыг үзэх
- ❖ **Selection tool** – Зөөх хэмжээг өөрчлөх
- ❖ **Pen tool** – Зангилаа цэгээр дүрс зурах, засах
- ❖ **Pencil tool** - Харандаагаар чөлөөт дүрс зурах
- ❖ **Rectangle Frame tool** – Текст зургийн жааз
- ❖ **Rotate tool** – Объектыг тэнхлэгээр эргүүлэх
- ❖ **Shear tool** – Объектыг налуулан ташуулах
- ❖ **Measure tool** – Объектын хэмжээг гаргах
- ❖ **Button tool** – Баттон зурах багаж
- ❖ **Hand tool** – Дэлгэцийг гүйлгэж харах
- ❖ **Default fill and stroke** – Объект ба хүрээ
- ❖ **Formatting effects container** – Жаазны эффект хийх
- ❖ **Normal view mode** – Баримтыг энгийн үзэх
- ❖ **Apply color** – Хүрээ ба объект будах зэрэг болно.

Зураг 4, **InDesign** програмын үндсэн багажнууд


Програмын тохиргоо

Бэлтгэж буй эхийн онцлог, эх бэлтгэгчийн өөрийн дадал зуршил, чадвар, хэрэгцээ шаардлага зэргээс шалтгаалж, ажлын талбарын тохиргоог хийх шаардлагатай. Зураг 5-д тохиргооны талбарыг харуулсан. Ажлын талбарын тохиргоо нь:

- Зөвхөн тухайн файлын хувьд ажлын талбарыг тохируулах
- Ерөнхий байдлаар ажлын талбарыг тохируулах гэсэн хоёр хэлбэртэй.

Програмын тохиргоотой холбоотой дараах боломжууд байдаг. Эдгээрт:

- **General** - хуудас дугаарлах, өнгөтэй холбоотой
- **Text** - текст форматлах, дэлгэцэнд харуулахтай холбоотой
- **Composition** - текстийг мөрөөр зэрэгцүүлэхтэй холбоотой
- **Units Increments** - хэмжих нэгжтэй холбоотой



Зураг 5 Тохиргоо хийх ажлын талбар

- **Guides & Pasteboard** - ажлын талбарт суурь шугамын тор татахтай холбоотой

- **Dictionary, Spelling, Notes** - англи хэл дээр баримт боловсруулахтай холбоотой тохиргоонуудыг хийх боломжтой.

Файлтай ажиллах

Шинээр баримт үүсгэхтэй холбоотой харилцах цонхонд цаасны хэмжээний захын зайтай холбоотой хэмжих нэгжүүдийг хэрэглэгч өөрийн хүссэнээрээ өөрчлөх боломжтой болохыг үзүүлсэн.

Баримтыг хадгалахад

- **Ctrl + S** : Энэ командаар хийж байгаа үйлдлүүд болон файлын өөрчлөлтийг хамтад нь хадгална. Энэ үед файлын санах ойд эзлэх хэмжээ их байна.
- **Ctrl + S Ctrl + Shift + S** : Энэ командаар хийж байгаа үйлдлүүд болон файлын өөрчлөлтийг эцсийн байдлаар хадгална. Энэ үед файлын санах ойд эзлэх хэмжээ эрс багасна.

Баримтыг хадгалах файлын форматад:


- **Indd** – InDesign үндсэн формат
- **Indt** – Файлыг загвар болгон дахин ашиглах зэрэг голлон ашиглагдана.

InDesign Saved Data - Янз бүрийн шалтгаанаар компьютер гэнэт унтрахад файл автоматаар энэ нэрээр хадгалагддаг.

Хуудастай ажиллах


Дэлгэцэнд хуваарийн болон туслах шугамууд харагддаг боловч хэвлэхэд харагддаггүй тал бий. (Зураг 6) Хуудсан дээрх объектуудын байрлал, хэмжээг тодорхойлоход маш чухал үүрэгтэй шугамнууд байдаг. Эдгээр шугамуудыг 3 ангилна:

- Margin Guides
- Column Guides
- Ruler Guides




Зураг 6 Хуваарийн болон туслах шугамууд

Хуваарийн болон туслах шагамуудын ашиглан нэг төрлийн шугамыг хэд хэдэн удаа давтан зурах шаадлагатай бол эхэлж татсан зураасыг сонгоод **Edit-Step and Repeat. . .** командын **step and repeat** цонхонд хэдэн удаа давтах, шугам хоорондын зааж өгч татна. (Зураг 7, 8) Үүнийг автоматаар шугамдах ч гэж нэрлэх тал бий.



Зураг 7 Автоматаар шугамдах



Зураг 8 Edit цэсний палитрууд


Edit цэсний командуудаар объектыг хуулах, зөөх, үржүүлэх, засварлах боломжууд, өнгөний ерөнхий тохиргоо, текст хайх, үйлдэл буцаах гэх мэт олон үйлдлүүдийг хийнэ. (Зураг 8)

Хуудастай ажиллах

Хуудастай ажиллахад **pages** палитрыг ашиглах бөгөөд ном хэдэн хуудастай болох, хуудасны дугаарлалт, бүлгийн мэдээллүүд энд харагдана. (Зураг 9) Эдгээрт

- Хуудас цэгцлэх
- Хуудас нэмэх
- Хуудас дугаарлах гэх мэт олон үйлдлүүдийг хийдэг.

Номыг ойлгомжтой, утгыг эмх цэгцтэй болгох үүднээс хэсэг бүлэг болгон хуваадаг.



Зураг 9 Хуудастай ажиллах

Текст өрөх хэлбэрүүд, текстийн жаазны тохиргоо хийх

InDesign програм нь **word** програм гэх мэтийн **word processing** програмууд дээр шивсэн их хэмжээний текстийг макетлах зориулалттай бөгөөд өөр дээрээ их хэмжээний текст шивж оруулахад зориулагдаагүй онцлогтой.


InDesign програмд текстийг

- *Зурмал объектод*: **Line, Rectangle, Ellipse, Polygon, Path** зэрэг багажаар бүтээгдсэн
- *Хүрээ жаазанд*: **Rectangle frame, Ellipse Frame, Polygon Frame** зэрэг багажуудар татсан
- *Бичгийн жаазанд*: **Type багаж, Mouse drag-and-drop** үйлдлүүдээр үүсгэсэн мужуудад байрлуулдаг.

Word, InCopy зэрэг програмын файлаас текст оруулахад **File - Place** командаар оруулах ба **Place** харилцах цонхноос файлыг сонгож дуудна. Орж ирсэн текст дээр хулганаар хоёр удаа товшиж, гарч ирэх цэснээс **Text Frame Options** командаар гарч ирэх харилцах цонхонд зарим тохиргоог хийх боломжтой.

Indesign програм нь 40 хүртэл багананд текст өрөх боломжтой. Програмд параграфтай ажиллахад **Paragraph** палитрыг ашиглана. (Зураг 10) Энд:


- Зэрэгцүүлэлт
- Догол мөр авах зай
- Баруун зүүн захаас авах зайг тохируулах гэх мэт олон тохируулгуудыг эндээс хийнэ.



Зураг 10 Paragraph палитрыг ашиглах

Үеэр таслах автомат тохиргоо

Тухайлбал, урт үгийн үеэр таслах горимын тохиргоог **Paragraph** палитрын контекстийн цэсний **Hyphenation Settings** ажлын цонхонд зааж өгнө.



Зураг 10 Hyphenation Settings тохиргоо

Түүнчлэн **InDesign** програмд зурагтай ажиллах их чухал ажил байна. Энд

Зураг зурахад **Pen tool** ба **Pencil tool**

Зурсан зургийг засахад **Add Anchor Point** ба **Scissors Tools**

Дүрс үүсгэн зурахад дараах командуудыг ашиглана: Эдгээрт:

Rectangle Tool ба Rectangle Frame tool

Ellipse Tool ба Ellipse Frame Tool

Polygon Tool ба Polygon frame Tool зэрэг болно.

Дүрс болон объекттой ажиллахад зургийн форматын тухай мэдлэгтэй байх шаардлагатай байдаг. Зургийн файлууд нь


- Photoshop – *.psd, *.tiff, *.tga
- Corel Draw - *.crd гэх мэт өөр өөр өргөтгөлтэй байх бөгөөд эдгээр бүх файлуудыг eps, jpeg, tiff, гэх мэт форматуудад хөрвүүлж хэрэглэдэг.

InDesign програмд зураг гаднаас оруулж ирэхийн өмнө **View** цэсний Display **Performance** дэд цэснээс Optimized, Typical, High Quality гэсэн гурван командын сонголтын нэгийг хийдэг. Дээрх гурван командын сонголтоор их хэмжээний файл дээр ажиллаж байх үед санах ойг үр бүтээлтэй ашиглахын тулд зургийн харагдах хэлбэрийг тодорхойлдог.

Мөн **InDesign** програм нь

- Зургийн жаазтай ажиллах
- Зургийн фоныг чөлөөлөх
- Зургийг замыг жаазанд хувиргах
- Интернэтээс зураг импорт хийж оруулах гэх мэт олон боломжуудтай.

Зураг оруулахдаа **File** цэсээс **Place** командын тусламжтайгаар оруулах ба **Show import options** сонголтыг хийснээр оруулах зургийн формат бүртэй холбоотой дэлгэрэнгүй тохиргоонууд бүхий харилцах цонх гарч ирэх ба үүнд шаардлагатай тохиргоонуудыг хийж өгнө.



Зураг 11 Зураг имфортлох

InDesign програмаар номын эхийг бэлтгэхдээ эх текстийг ердийн текст редактор програм ашиглах нь зүйтэй юм. Үүний дараагаар текстийн файлаас импорт хийж оруулах нь тохиромжтой. INDESIGN програмд багажаас гадна палитруудыг ихээхэн ашигладаг. Ямар багаж идэвхитэй байгаас хамааран төлөвийн мөр болон палитрууд өөрчлөгдөж байдаг. Олон зохиогч хэсэгчлэн зохиосон номыг монтаж хийхдээ **book** палитрыг ашигласанаар дугаарлах гэх мэт үйлдлийг хийхэд хялбар болно.

Гарчиг түүвэрлэх, нэрийн хэлхээс хийхэд параграфын загвар ашигласан бол **InDesign** програмын **Table of Contents** ажлын цонхонд гарчгийг автоматаар ямар түвэггүй бүрдүүлэх боломжтой.

Мэргэжлийн нэр томъёо орсон ном бэлтгэхэд тайлбар оруулахдаа **Indesign** програмын Index палитрыг ашиглан хийх боломжтой болсон.

Бид тус програм дээр ажиллаж байх явцад багаж, хэлбэршүүлэх самбар, нэмэлт самбаруудыг өргөн ашиглах боловч зарим нь тийм ч их ашиглагдахгүй үлдэнэ. Хамгийн өргөн ашигладаг зарим нэг самбарын талаар авч үзье.

Info- Мэдээлэл өгөх самбар хулганы заагчийн байрлал, объект сонгосон тохиолдолд түүний өргөн өндрийн хэмжээ, өнгийн хольцийн хэмжээ, нягтрал зэргийг мэдээллэх үүрэгтэй.

Харин текст сонгосон тохиолдолд нэмэлтээр хэдэн тэмдэгт, хэдэн үг зэргийг харуулна. Selection багаж сонгосон үед тухайн файлын нэр, байрлал, хэмжээ зэргийг харуулдаг.

Navigator- Цаасны харагдах байдлыг масштабээр ихэсгэж багасгаж харах, мөн цаасаа гүйлгэх үйлдлийг хялбар хийхэд зориулагдсан. Тус самбар дээр таны хийж байгаа ажлын цаас тоймлон харагдана. Түүн дээр улаан өнгийн дөрвөлжин байх ба түүнийг зөөж, мөн самбарын доод хэсэгт байрлах гүйлгэгчийг ашиглан харагдах хэлбэрийг томруулан жижигрүүлэн өөрчилж болно. Мөн гүйлгэгчийн өмнө масштабын хувь байх бөгөөд түүнийг өөрчилж болно.

Хэвлэлийн зориулалттай хэвлэмэл болон дижитал мэргэжлийн хуудас хийхэд зориулагдсан програм болох Adobe InDesign нь хэвлэл, вэб, таблет болон бусад төрлийн төхөөрөмжүүдэд зориулж олон төрлийн агуулга боловсруулах, урьдчилан харах, хэвлэх, нийтлэх боломжийг олгодог.

Энэхүү програм хангамж нь хэрэглэгчид бүтээлчээр сэтгэн өөрийн гэсэн дизайн боловсруулах болон Adobe Photoshop, Illustrator, Acrobat, Adobe Animate нартай интеграци хийж хослон ажиллуулах боломжийг олгодог.

InDesign-ийг сэтгүүл, дизайны фирм, зар сурталчилгааны агентлаг, сонин, номын хэвлэлийн газар, жижиглэнгийн худалдаа / каталогийн компаниудад ажилладаг дизайнерууд, хэвлэлийн өмнөх бэлтгэл, үйлдвэрлэлийн мэргэжилтнүүд, хэвлэх үйлчилгээ эрхлэгчдэд зориулагдсан бөгөөд компанийн дизайнер болон маркетингийн хэлтэст ажилладаг төрөл бүрийн ажилтнууд, мөн сошиал маркетинг хийдэг, постер, гарын авлага, бүтээгдэхүүний танилцуулгатай ажилладаг бүхий л төрлийн хүмүүс уг програмыг суралцах боломжтой. Мөн өөрийгөө хөгжүүлж ажлын ур чадвараа нэмэгдүүлэхийг хүссэн хэн бүхэнд уг програм тус болно гэдэгт итгэлтэй байна.

InDesign дахь туслах шугамууд

Номын эх бэлтгэгч хэмжээ, баримжаа авах төрөл бүрийн шугам хэрэгтэй болдог. Тэгвэл InDesign-ний хувьд дэлгэц дээр харагдах мөртлөө хэвлэгддэггүй нарийн шугамуудыг туслах шугамуудыг хуудасны хаана ч зөөж болох ба тэдгээрээр модулийн тор байгуулна.

InDesign-ний модулийн тор нь дараах гурван туслах шугамаас бүрдэнэ. Үүнд:

Margin guides буюу поляны хязгаар. Хуудсан дахь эх бэлтгэлийн нүүрийг поля буюу захын цагаан зайнаас тусгаарлах нарийн ягаан шугам. Түүнийг курсороор зөөж болохгүй ч поля буюу margins нүдэнд дөрвөн талын утга өгөх замаар загвар хуудсанд тохируулан өөрчилнө. Column guides буюу баганын хязгаар. Багануудыг хооронд нь тусгаарлаж буй босоо цэнхэр шугам. Багана хоорондын зай гэдэг нь угтаа баганын хязгаарын зай гэнэ.

Ruler guides буюу тиг зураас. Хуваарийн шугамаас курсороор татах (бас товших) замаар хэдэн ч удаа татан гаргаж хуудсанд босоо болон хэвтээ чигт чөлөөтэй байрлуулж болох ухаа өнгийн (мэдээж өнгийг өөрчилж болно) тусгай шугам.

Макет (Layout) горим идэвхтэй нөхцөлд бүх туслах шугам ил гарч харагддаг.

Тиг зураас гараар татах

Дэлгэцийн зүүн ба дээд ирмэгээр байрладаг хуваарийн шугамаас хулганын чирэх даралтаар Ruler guides буюу тигзураасыг босоо ба хэвтээ тэнхлэгт хэдийг ч татан гаргаж болно. Эсвэл хуваарийн шугам дээр дараалан товшиход тиг зураас ажлын талбарт тавиадана. Мөн босоо байрлалтай шугамыг Selection багажаар сонгож зөөхдөө Control Panel палитрийн Х нүдний утгаар мм-ээр шилжүүлж болно. Гэхдээ тигзурааснуудыг хооронд нь ижилхэн зайтайгаар өрөхдөө <Ctrl> товчоор зэрэг идэвхжүүлж байгаад Use Spacing горимыг асаан арынх нь нүдэнд алхмыг бичиж босоод зэрэгцүүлэх пиктограм дээр дарна.

Номын сангаас хулганаар шууд чирж зургийг макетад оруулж болох ба палитрийн Place Item(s) командаар ч зургийг оруулна. Мөн Add All Items on Page командаар эх бэлтгэсэн бүхэл бүтэн нүүрийг тэр чигээр нь номын санд оруулах боломжтой бөгөөд энэ тохиолдолд макетын зурагнууд хуудсан дахь дарааллаараа жагсаж орно.

Ашигласан материал

References

Б.Туяацэцэг Мэдээллийн технологи ба мэдээллийн систем

“Basic skills of Information Technology”, Tuyatsetseg Badach, Soyombo Printing, 2016.

“Skills of Information Technology and Information Systems”, Tuyatsetseg Badarch, Soyombo Publishing, 2019, page 170, ISBN 99929-9-0821, Ulaanbaatar, Mongolia.